МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 23 өдөр Дугаар А/24 Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.7, 15.9, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль, эрх зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 02-ны ээлжит XVIII хуралдааны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хуулийн этгээдийн хүсэлт, ажлын хэсгийн дүгнэлтийг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох жагсаалтыг хавсралтаар батлсугай.

2. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа А.Алтанцоож), аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10, 2016 оны А/194 дүгээр захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат) нарт тус тус даалгасугай.

ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж2024

6712010070

Аймгийн Засаг даргын орлогчийн 2024 оны
01 дугаар сарын 23-ны өдрийн
А/24 дугаар захирамжийн хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖАГСААЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Хуулийн этгээдийн нэр	Байршил		
1	“Анунхангай” ХХК	Мөрөн сумын 3-р баг 3-21-20 “S2N Hypermarket”	88117700	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
2	“Мөнх дарцагт” ХХК	Мөрөн сумын 4-р баг 4-6-1 “Маамуу нааш ир-1” Хүнсний дэлгүүр	99051933	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
3	“Мөнх дарцагт” ХХК	Мөрөн сумын 3-р баг 3-2-32 “Маамуу нааш ир-2” Хүнсний дэлгүүр	99051933	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
4	“Өгсөх урсгал” ХХК	Цэцэрлэг сумын 5-р баг “Уран дөш” дэлгүүр	95909099	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
5	“Смарт Мутоз” ХХК	Цэцэрлэг сум 5-р баг “Тулга” хүнсний дэлгүүр	88069878	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
6	“Тэсийн удамт урлан” ХХК	Мөрөн сумын 12-9-1“Маргад-Эрдэнэ” хүнсний дэлгүүр	99063466	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
7	“Гундан тосон” ХХК	Цагаан-Уул сум 6-р баг 3-29 тоот “Тосон” хүнсний дэлгүүр	99506262	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
8	“Хогорго тэнгис” хоршоо	Рэнчинлхүмбэ сум 6-р баг “Хоймор төв” хүнсний дэлгүүр	89483828	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах

---oOo---